

Тэр бас зураг зурах дуртай, ялангуяа хийсвэрлэх аргаар хүний янз бүрийн төрх байдлыг гаргахдаа тун чадмаг. Түүний зурсан зургийн өнгө хурц тод, хүний таашаал өөрийн эрхгүй татдаг. Ван үе үе өөрийн дүрслэх урлагийн бүтээлийн үзэсгэлэн гаргадаг байна.

Пумипон бол биеийн тамирын арга хэмжээг тууштай дэмжигч, өөрөө ч биеийн тамираар идэвхитэй хичээллэдэг. Урьд Швейцарт байхдаа машины уралдаан, далбаат завь, өдөн бөмбөг шимтэн сонирхдог байлаа. 1966 онд тэрбээр далбаат онгоц жолоодон Тайландын буланг 18 цагт туулжээ. 1987 онд Олон улсын олимпын хороо үүнийг үнэлж хамгийн хүндтэй одонгоороо шагнажээ.

Вангийн идэвхи санаачлагаар бухны мөргөлдөөн, заан сургах, загас зодолдуулах, могойгоор наадах зэрэг Тайландын үндэсний уламжлалт наадам сэргэн хөгжиж цаасан луу хөөргөх, усанд дэнлүү тавих ёслол, үр суулгасны баяр зэрэг ардын зан үйл өрнөн дэлгэрэх болжээ. Энэ мэт баяр наадам, зан үйл нь цэцэглэн хөгжиж буй Тайланд орныг улам өнгө жавхаалаг болгож байна.

Хятадын «Рен Ү» сэтгүүлээс орчуулсан **Д. Шүрхүү**

ИНДОНЕЗИЙН «РОКФЕЛЛЕР»- ЛИНЬ ШАОЛЯН

Линь Шаолян, энэ нэгэн нэр Индонез төдийгүй Зүүн өмнөд Ази, бусад орнуудын үйлдвэр-худалдааныхны дунд аль хэдийн танил дотно болжээ. Гэвч 40-өөд жилийн тэртээ жирийн жижиг худалдаачин байсан хүн дэлхийн 6 дахь том баян болсны нууцыг хүмүүс мэдэхийг ихэд хичээдэг гэнэ. Индонезийн 1-р баян Линь Шаоляны бүх хөрөнгө Америкийн Рокфеллерийнхийг давж 7 тэрбум ам. долларт хүрчээ. Энэ хүний мэдэлд хэд хэдэн банк, мод боловсруулах үйлдвэр, уурхай, электроник, автомашин, усан онгоц, зочид буудал, даатгал, газар тариалангийн, зам тээврийн гэх мэт 192 пүүс, үйлдвэрийн газар бий. Мөн 60-аад оны үед үйл ажиллагаагаа эхэлсэн Азийн төв банк, 70-аад оны эхээр Сингапурт байгуулагдсан Хуажэньи банк бас Линь Шаолянтай холбоотой бөгөөд эдийн засгийн янз бүрийн салбарыг санхүүгийн талаар дэмждэг юм. Гадаад орнуудад хөрөнгө оруулалтаар хэд хэдэн үйлдвэрийн газар байгуулсан байна. Үүнээс гадна АНУ-ын Калифорни муж улсын нэгэн банк, Америкийн Хуатун банкиг эзэмших эрхийг тус тус олж авсан нь АНУ дахь түүний байр суурийг бэхжүүлжээ.

1975 онд ашиглалтанд орсон цементийн үйлдвэр жилдээ 10 сая тонн бүтээгдэхүүн гаргадаг. Үүний ачаар Индонез улс цементийг урьд өмнө гадаадаас авдгаа больж экспортоор гаргадаг болсон байна. Энэ бол Линийхний хамгийн том үйлдвэрийн газар бөгөөд түүнтэй зэрэгцэх ижил том үйлдвэр өөр аль ч оронд үгүй ажээ.

Индонезийн төмөрлөгийн үйлдвэрийг байгуулахад зарцуулсан хөрөнгийн 40%-ийг Линь Шаолян гаргасан. Уг үйлдвэрийн хөрөнгө оруулалтанд оролцохоор шийдэхэд нь бусад хүмүүс «ийм их зардал шаардсан дэмий юманд мөнгөө урсгах хэрэг юун» гэж эргэлзэж байжээ. Гэтэл төмөрлөгийн үйлдвэр ажиллаж эхэлсний дараахан Линий шийдвэр зөв болох нь харагдсан юм. Индонезийн өмнө өөрийн хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх ирээдүй ингэж нээгдэв. Линь Шаоляныг хүмүүс «Индонезийн Рокфеллер» хэмээн энэ цагаас нэрлэх болжээ.

Линь Шаолян 1917 онд Хятадын Фузянь мужийн Фуцин гацаанд ядуу тариачны гэрт төржээ. 21 насандаа ядуу зүдүүгийн улмаас харь оронд цагаачлан амь зуухаар шийдэж тэр үед Индонезид жижиг худалдаа эрхэлж байсан авга ах дээрээ ирэв. Эхлээд хувийн жижиг дэлгүүрт тоо бүртгэгчээр ажиллаж дараа нь бие даан кофены үрэл худалдав. Шөнө дунд кофегоо нунтаглан жижиглээд цаасанд боож өдөржин 60-70 ли* хол газар явж худалдана. Тэр үеийн амьдрал нь ч нэлээд хүнд бэрх байжээ. Линь Шаолян тэр үеийг эдүүгээ эргэн санахдаа «хүн зовж байж л амьдралын сайхныг үздэг жамтай юм даа» гэж ярьдаг гэнэ. Японыг эсэргүүцэх дайн дууссаны дараа Индонезид тамхины том жижиг үйлдвэрүүд олноор гарч ирлээ. Тамхины түүхий эд болон лишь цэцэг чухал хэрэгцээтэй эд болохыг Ли Шаолян ойлгон дээрх үйлдвэрүүдэд түүхий эд нийлүүлэх ажлыг эрхэлж эхлэв. Үүний ачаар ихээхэн орлого олсон нь хожим үйлдвэр, пүүс байгуулахад нь онцгой үүрэг гүйцэтгэжээ.

1960 оны эхээр Линь Шаолян унадаг дугуйны резин гадаргуу хийдэг 6 ажилчинтай жижиг үйлдвэр нээж удалгүй хувцас, хүнс, орон сууцны барилга ирээдүйд орлого ихтэй болохыг урьдчилан харсны үүднээс нэхмэл, гурил, цементийн 3 үйлдвэр байгуулахын хамт ерөнхийлөгч Сухартогийн төрлийн хүмүүстэй хөрөнгө хоршсон үйлдвэр барьж 1968 онд Засгийн газрын зөвшөөрлөөр лишь цэцэг гадаадаас авах тусгай эрх авав. Капитал өсөхийн хирээр шинээр «Худалдааны Хуажэнь» пүүс байгуулав. Хожим 1982 онд энэ том пүүс АНУ-ын Сан-Францискогийн нэгэн компанийн хувьцааг, Гонконгийн бас хэд хэдэн банкныг өөрийн мэдэлд авсан. Линь Шаоляны ажил хэрэг улам л өөд ахих болжээ. 1960-аад оноос Линь Шаолян зах зээлийн ширүүн өрсөлдөөнд ялахын тулд үйлдвэрлэлийн орчин үеийн арга хэлбэр чухал болохыг ойлгожээ. Тэр хэлэхдээ: «үйлдвэрлэлийн тэргүүний аргыг хэрэглэн гадаад орнуудад хөрөнгө оруулж өөрийн үйлдвэрүүдээ байгуулах нь дампуурлыг зайлуулахад тустай, эдийн засгийг олон улсын хэмжээнд хүргэх нь цаг үеийн алхам болно» гэжээ. Линь Шаолян олон улсын худалдаанд шаргуу зоригтой оров. Түүний баримталдаг гол зарчим нь чадлаараа сэтгэж арга зам хай, бүх боломжоо дайчилж ажилла, өөрийн өртөг хямд бүтээгдэхүүн гаргах, чанарыг голлох, зах зээлийн өрсөлдөөнд ялах» зэрэг болно.

Тэр өөрийн 3 хүүг барууны орнуудад суралцуулж орчин үеийн менежмент, эдийн засгийн арга ухааныг эзэмшүүлжээ.

Линь Шаолян эдийн засгийн тийм ч өндөр боловсролтой хүн биш. Гэвч олныг нэгтгэн удирдах, хүний авьяас ухааныг ашиглах талаар сүрхий туршлагатай. Хаана ч, ямар ч ажил дээр гагцхүү хүний хүчин зүйл тэргүүлэх үүрэгтэй, техник хэрэгсэл бол туслах үүрэгтэй, ажилдаа эзний ёсоор хандвал сая амжилтанд хүрнэ гэж тэр ярьдаг. Хүнтэй ажиллахад 2 гол зарчмыг баримтална: хүнийг чадлынх нь хирээр ажиллуул, гэвч бүхнийг хүнээс бүү шаард; хүнд итгэж бай, итгэхгүй бол ажил бүү хийлгэ. Линь Шаоляны олон пүүс, үйлдвэр банк гайхамшигт амжилтанд хүрч чадсаны бас нэг нууц түүний хамтран ажиллагчийгаа зөв сонгож чаддагт оршино. 1972 онд Линь Шаолян Гонконг орох замдаа нисэх онгоцонд Ван Ин банканд урьд ажиллаж байсан Ли Вэньжэнтэй танилцаж хэсэг хугацаанд ярилцсаны дараа Азийн Төв банканд ажиллахыг санал болгожээ. Ли Вэньжэн саналыг дуртай зөвшөөрөв. Удалгүй Ли Вэньжэн санхүү банкны талаар өндөр чадвар-

*Ли-0,5 км

тай мэргэжилтэн болохоо харуулж хожим Азийн төв банк Индонезийн хувийн хамгийн том банк болж түүний хувьцааны 17,5% -ийг Линь Шаолян Вэньжэньд шилжүүлжээ.

«Хэрэглэгчдийг чин сэтгэлээсээ үйлчилдэг» нь амжилтын өөр нэг нууц нь ажээ. Тэр ярихдаа «...худалдаа хийхэд эхлээд хэрэглэгчдийнхээ төлөө үйлчилье гэсэн сэтгэлийг өөрт төлөвшүүлэх хэрэгтэй. Тэдэнд тун дотносог хандаж эрэлт хэрэгцээг нь эн тэрүүнд тавих аваас байнгын хэрэглэгчтэй болох учиртай» гэжээ. Линь Шаолян худалдааг өндөр ёс суртахуун шаардах ажил гэж үздэг. «Индонезийн Рокфеллер» цамаан хээнцэр занд дургүй, тун энгийн даруу байхыг хичээдэг. Тэднийх Жакарт хотод бусдаас ялгарахааргүй жирийн хуучирсан байшинд суудаг. Эхнэр нь мөн нөхрийн адил биеэ даруухан авч явдаг ажээ. Тэр хоёр хүүхдүүд, ач нартаа аль болохоор төлөв даруу, ажил хөдөлмөрт шамдан суралцахыг захидаг.

Линь Шаолян хар багаасаа ажилч хичээнгүй, арвиг хямгач занг өөртөө төлөвшүүлжээ. Найз нөхөддөө тусархаг, тэр тусмаа өөрийн биш үйлдвэрийн газруудад мөнгөн хандив оруулдаг байна. Найр наадам, оршуулга, цайллага гэх зэргийн ажилд илүү зардал гаргахгүй байхыг бусдад захидаг. Тэр ярихдаа нийгмээс хүртсэн баялгийг тэр нийгэмд нь л зориулна, ингэвэл сэтгэл санаанд сайхан байдаг гэжээ. Линь Шаолян архи тамхи хэрэглэдэггүй, биеийн тамираар хичээллэдэг учир бие эрүүл, ухаан саруул хүн юм. Ажлын бус цагаараа ном сонин, сэтгүүл унших дуртай, ялангуяа дотоод гадаад мэдээ, эдийн засгийн холбогдолтой материалыг ихэд сонирхдог.

Линь Шаоляны гавьяа юунд оршиж байна гэсэн асуултанд товчоор хариулахад Индонезийн эдийн засгийн хөгжлийг хэдэн арван жилээр хөгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн гэж болмоор санагдана.

Линь Шаоляны хувьд дээд зэргийн аз жаргал нь юу гэвэл бүтээх явдал юм. Бүтээсэн хийсэн бүхнийхээ үр дүнг харж суух бол амьдралын жаргал, бүтээсэн зүйл нь нийгэм, хүн олонд сайн сайхныг авчирч байвал амьдралын зорилго түүнд орших ажээ.

Орчуулсан **Д. Наран**